

ТАНИЛЦУУЛГА

*Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд
хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх
журмын төслийн тухай*

Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг хэлэлцэн баталсан ба 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Тус хууль батлагдсантай холбоотойгоор Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.2.4-т “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах” зохицуулалтыг тусгасан.

Энэхүү журмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулахаар 6 бүлэг бүхий журмын төслийг боловсрууллаа.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхдэд тулгарч буй аюултай нөхцөл байдлыг арилгах, хүүхэд хамгааллын шуурхай тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хариу үйлчилгээг төлөвлөх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, санхүүжилт, тайлагналт, хяналт шинжилгээтэй холбогдсон зохицуулалтыг энэхүү журмын төсөлд тусгасан.

Мөн журмын төсөлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд Хүн худалдаалах гэмт хэргийн салбар дундын хамтарсан баг зохион байгуулалтын удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах зохицуулалт тусгагдсан болно.

Журмын төсөл батлагдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах, хэвийн амьдралд нь эргэж оруулах, тэдний хөгжлийг дэмжихэд оролцож буй төрийн болон төрийн бус байгууллагуудын чиг үүрэг тодорхой болж, Монгол Улсын олон улсын гэрээгээр өөртөө хүлээсэн үүргээ биелүүлэх, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой.

---oOo---